



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 10 сарын 10 өдөр

Дугаар 11/535

Номгон


Аймгийн өрсөлдөх чадварыг сайжруулах  
арга хэмжээнд хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.3, аймгийн 2023 оны хөгжлийн төлөвлөгөөний 6.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн өрсөлдөх чадварыг сайжруулах арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах 5000.000 (таван сая) төгрөгийг аймгийн хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Байгалмаа) -д зөвшөөрсүгэй.

2. Аймгийн өрсөлдөх чадварыг сайжруулах арга хэмжээний төлөвлөгөөг үр дүнтэй хэрэгжүүлж, гарсан үр дүнг танилцуулахыг Баянхонгор аймаг дахь Худалдаа аж үйлдвэрийн танхим (Г.Энхтүвшин) -д даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Энхжаргал) -д үүрэг болгосугай.



ДАРГА

Д.МӨНХСАЙХАН